

УЛС ТӨР, ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА

Д. Даш.

**БЭЭЖИНГИЙНХЭН ХЯТАДЫН МИЛИТАРИСТУУДЫН
БОДЛОГЫГ ҮРГЭЛЖЛҮҮЛЖ БАЙНА**

Бээжингийн эрх баригдчын их гүрний дээрэнгүй үзлийн нэг илрэл нь тусгаар тогтносон бүрэн эрхт Монгол Ард Улсын тухайд баримталж буй бодлого мөн. Хятадын эрх баригчдаас Монголын эсрэг явуулж буй бодлогын уг сурвалж нь БНМАУ эрх чөлөөтэй, тусгаар тогтнон оршихын найдвартай баталгаа болсон монгол-зөвлөлтийн ард түмний найрамдлыг эвдэн бусниулж, чухамхүү тэр үндсэн дээр тус улсыг өөртөө хавсарган нэгтгэх хэзээний түрэмгий санаархлаа биелүүлэхэд чиглэж байгаа юм.

Хятадын эрх баригчид социалист орнуудын харилцааны асуудалд ангич шугам, интернационалч байр сууринаас хандах марксист-ленинист зарчимд огт үл нийлэлцэх жанжлан захирах, булаан эзлэх илэрхий милитарист чиг шугам баримталж байгаа нь БНМАУ-ын талаар явуулж буй хятадын эрх баригчдын сүүлийн үеийн үйл ажиллагаанаас улам тодорхой харагдаж байна.

Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн хурлын чуулган дээр Монголын нутаг дэвсгэрээс цэргээ татан гаргах шаардлагыг хятадын удирдлага Зөвлөлт Холбоот Улсад тавьсан нь бүрэн эрхт социалист Монгол улс оршин тогтнож байгааг үл тоомсорлон, Монголын ард түмний хувь заяаг түүний хууль ёсны засгийн газрын ар хударгаар шийдвэрлэх гэсэн балмад оролдлого мөн.

БНМАУ-ын засгийн газраас 1978 оны дөрөвдүгээр сарын 12-нд Хятадын засгийн газарт өгсөн нот бол хятадын эрх баригчдын тэрхүү эрээ цээрээ барсан дээрэнгүй явууллагад өгсөн зүй ёсны няцаалт, монголын нийт ард түмний санал зоригийн бүрэн илрэл юм.

БНМАУ-ын засгийн газрын нот бичигт Зөвлөлтийн цэргийн ангиудыг Монголд байлгаж буй учир шалтгаан бол хятадын эрх баригчдаас БНМАУ-ын талаар явуулж байгаа бодлогод оршиж байгаа юм гэдгийг тодорхой зааж, хятадын зүгээс довтлон халдах аюул арилсан тэр цагт Зөвлөлтийн цэргийн ангиудыг гаргах тухай асуудал яригдаж болох юм гэж тэмдэглэсэн байна.

БНМАУ-ын Засгийн газрын энэхүү зарчимт бодлогын агуулга нийтэд тодорхой юм. Хятадын эрх баригчид олон улсын хууль зүй, хоёр орны хооронд байгуулсан гэрээ хэлэлцээрийг үл хайхран БНМАУ-ыг Хятадад нэгтгэн хавсаргах санаархлаа нэг биш удаа мэдэгдэж байсан төдийгүй түүнийгээ практик алхмаар лавшруулж БНМАУ-ын аюулгүй байдалд шууд занал учруулсан юм. Хятадын эрх баригчид БНМАУ-ын хил дээр түгшүүртэй байдлыг зориуд буй болгож, үлэмж хэмжээний цэрэг стратегийн холбогдол бүхий барилга-байгууламжийг олноор барьж байгаагийн гадна, хил зөрчих явдал үргэлжилсээр байна. Ийм нөхцөлд БНМАУ-ын Засгийн газар улс орныхоо аюулгүй байдлыг хангах эрх ашгийн үүднээс шаардлагатай бүх арга хэмжээ авч, Зөвлөлтийн цэргийн ангиудыг 1966 оны найрамдал, хамтын ажиллагаа, харилцан туслалцах

тухай Монгол-Зөвлөлтийн гэрээний дагуу урьж ирүүлсэн нь БНМАУ-ын жинхэнэ дотоод хэрэг мөн гэдэг нь нийтэд илэрхий юм.

Тусгаар тогтносон Монгол улсын бүрэн эрхийг үл тоомсорлосон хятадын засгийн газрын дээрэнгүй явууллага нь 20-30-аад оны үед хятадын милитарист болон Чан Кай-шийн харгис дэглэмийн зүгээс шинэ тулгар хувьсгалт Монгол улсын эсрэг явуулж байсан түрэмгий үйл ажиллагааны талаархи түүхийн баримтуудыг аяндаа санагдуулж байна. Хятадын удирдагчдаас БНМАУ болон түүний холбоотон ЗСБНХУ-ын эсрэг цэрэг дайны бэлтгэлээ улам хүчтэй болгож байгаа явдлын үзэл суртлын сурвалж нь нэн харгис үндсэрхэг үзэл, их гүрний шовинист бодлого мөн учраас тийнхүү түүхэн уламжлалын холбоотой байгаа нь гайхалтай хэрэг биш юм. Хөрш орнуудын хил хязгаарт өнгөлзөн, нутаг дэвсгэрийн талаар ор үндэсгүй шаардлага тавьж байгаа нь Бээжинийн эрх баригчид марксизм-ленинизм, пролетарийн интернационализмын зарчмаас тасран салж, Хятадын феодал, хөрөнгөтний үндсэрхэг үзлийн хамгийн харгис талуудын өвлөн авсныг харуулж байна. Ардын Засгийн газрын хүсэлтээр 20—30-аад оны үед Улаан цэргийн ангиуд Монголд орж ирсэн тухайд Хятадын милитаристууд ба гоминданы харгисуудаас дэгдээж байсан эл дэд шуугиан, өдөөн хатгалгын тухай асуудлыг үүнтэй холбогдуулан дурдаж болох юм. Ардын хувьсгалын ялалтын үрээр шинэ тулгар Монгол улс үүсэн тогтносныг их хан үндэсний дээрэнгүй үзэлд автсан Хятадын Милитаристууд огтхон ч зөвшөөрөхгүй байлаа. 1921 оны хавар Бээжин хотноо хятадын ерөнхийлөгчийн удирдлагаар тусгай зөвлөлгөөн болж нэн даруй цэрэг хөдөлгөн Монголд өрнөж байгаа хувьсгалт хөдөлгөөнийг дарах шийдвээр гаргасан юм. Хятадын ерөнхийлөгчийн зарлигаар генерал Чжан Цзо-лин Гадаад Монголыг «илбэн тохинуулах» сайдаар томилогджээ. 1921 оны наймдугаар сард тэрбээр Монголын хүн амд хандаж гаргасан нэг бичигтээ: «Гадаад Монгол бол Дундад иргэн улсын таван угсаа лугаа хамтаар найрамдах нэгэн нь мөний тул өөр хүнд дураар гишгүүлэх ёсгүй... Монголчууд эндүүрлээ хүлээж зэвсгээ хураалгагтун, үгүй ахул цэргийн хүчнээр хядан дарж уг үндсийг арилгана»¹ гэж сүрдүүлж байв.

Монголын ард түмний хувьсгалт ололтыг устгах гэсэн хятадын харгис хүчний эрмэлзэл нь Монголын биеэ даасан байдлыг үл зөвшөөрөн, шууд байлдан дагуулах гэсэн оролдлогоор илэрч байсан юм. Гэвч ажилчин-тариачны улаан армийн ангиуд Ардын Засгийн газрын хүсэлтээр Монголд байсан явдал Хятадын милитаристуудын зүгээс тус орны эсрэг цэргийн шууд довтолгоон хийх боломжийг нэн хомстосон байна. Ийм нөхцөлд хятадын эрх баригч бүлгийнхэн дипломат шугамаар Зөвлөлт Орос Улсад даралт үзүүлэх гэж элдвээр оролдсон юм. Тэд «Монголын асуудал» гэгчийг зохиомлоор сэдэн үүсгэж, Улаан армийн ангиудыг Монголоос гаргах явдлыг Зөвлөлт Орос Улстай хэвийн харилцаа тогтоох талаар хэлэлцээр хийж эхлэхийн нэг урьдчилсан нөхцөл болгон тавьж, монгол-зөвлөлтийн 1921 оны гэрээг цуцлахыг шаардаж байв².

Монголын асуудлыг улс түмний өөртөө засан тохирох эрхийг хүндэтгэх үндсэн дээр шийдвэрлэх ёстой гэж Зөвлөлт Орос Улсын Засгийн газар үзэхдээ «Монголын дотоод хэрэгт ямар ч гадаадын хүн нар оролцох эрхгүй, 1913 оны гэрээ бичгийг зогсоож, Монгол улс тусгаар тогтносон орны ёсоор Бээжин, Петроград хоёроос асуулгүй, аливаа олон улс

1 Намын түүхийн институтын Намын төв архив. ф-1, Т-6, ХН-117.

2 «Монгол-Зөвлөлтийн харилцаа» баримт бичгүүд, УБ., 1977 68—69-р тал.

лугаа шууд харилцан нэвтрэлцэх эрхтэй»³ гэж бүр 1919 онд тунхагласан зарчимт байр сууриа хатуу баримталж байсан юм. Зөвлөлт Орос Улсаас Хятадад сууж байсан бүрэн эрхт төлөөлөгч А. Гайкис 1922 оны хоёрдугаар сарын 1-нд Хятадын Төв Засгийн газрын төлөөлөгч Ли Юань-д өгсөн нотдоо Монголоос зөвлөлтийн цэргийн ангиудыг гаргах асуудлын талаар баримталж байгаа Зөвлөлт Засгийн газрын бодлогыг тодорхой тайлбарлажээ. Зөвлөлтийн цэргийн зарим анги Монголын Ардын Засгийн Газрын хүсэлтийн дагуу тэнд түр оршиж байгааг заахын хамт, Бээжингийн засгийн газар Монголын хувьсгалт засгийн газартай хэлэлцээ хийж харилцаагаа нэн даруй зохицуулаасай гэж хүсч байгааг тэрхүү нотоор илэрхийлсэн байна.⁴ Зөвлөлт Засгийн газар улаан армийн ангиудыг гаргах явдлыг тус орны аюулгүй байдлын баталгааг бий болгох асуудалтай ийнхүү холбож тавьснаар Монгол улсын тусгаар тогтнолын асуудал нэн эгзэгтэй байсан тэр үед үнэхээр бодит дэмжлэг үзүүлсэн билээ.

Зөвлөлт Орос Улстай тогтоосон цэрэг-улс төрийн холбоонд тулгуурлан, Монгол Ардын Засгийн газар хятадын эрх баригчдын занал сүрдүүлэгт огтхон ч авталгүй, хувьсгалт ололтоо хамгаалах зориг хүслээ тов тодорхой илэрхийлсээр байсан юм. Монгол улсын ерөнхий сайд Б. Цэрэндорж 1923 оны өвөл «РОСТА» агентлагийн сурвалжлагчтай ярилцахдаа: «Эдүгээ Монголыг автономит байдалт буюу сюзернитет эрхтэй улс болгон өөрчлөх тухай ямар нэг яриа байж болохгүй нь мэдээж хэрэг. Тэгж ярих цаг аль хэдийнээ өнгөрчээ. Монгол улсыг тусгаар тогтносон улс хэмээн хүлээн зөвшөөрөх явдал бол цорын ганц зам, тэгэхдээ сонирхогч бүх этгээдэд тохирсон зам юм. Асуудлыг өөрөөр тавих нь хүнд бэрхшээл л гаргахаас өөр юунд ч хүргэж чадахгүй»⁵ гэж мэдэгджээ.

Хятадын доторхи хувьсгалт хүчинтэй эв санааны нэгдлээ батжуулах арга замыг сүвэгчлэхээр 1923 оны эцсээр Бээжин, Гуадун зэрэг хотноо очсон Монгол Ардын Намын Төв Хорооны дарга хятадын сонин сурвалжлагчидтай уулзаж ярилцахдаа Монголд улаан армийн зарим анги түр байрлаж буй бодит шалтгааныг тайлбарлаж, тэрхүү цэрэг монголын дотоод хэрэгт оролцож байгаа мэтээр хятадын хэвлэлд нийтэлсэн ор үндэсгүй мэдээг эрс няцаасан юм. «Оросын хааны монголыг залгия гэсэн бодлогыг шинэ засаг гээж устгасныг манай монголчууд гүнээ мэдсэн бөгөөд Зөвлөлийн Засагт Орос Улс манай Монголын үнэхээр сайн нөхөр Мөн болох тул, бас манай олон ардын эрх чөлөөгөө олох явдалд мөн ч тусламж үзүүлсэнд манай монголчууд туйлаар сүслэн буй»⁶ гэж тэрбээр сонин сурвалжлагчийн асуултанд хариулжээ. Үндэсний ба нийгмийн хувьсгалын замаар сэргэж мандсан манай ард түмний түүхэн ололтыг үл тоомсорлон, Монголыг хавсарган нэгтгэх шунахай бодлогоо биелүүлэхийн тулд Зөвлөлтийн цэргийн ангиудыг Монголоос нэн даруй гаргахыг шаардаж байсан хятадын милитарист бүлгийнхний явууллагыг шинэ тулгар монголын засгийн газар болон олон нийт ийнхүү шийдвэртэй няцааж байсан юм.

Хятадын доторхи ардчилсан, дэвшилт хүчний төлөөлөгчид зөвлөлтийн цэргийн ангиуд түр байгаа явдлын учир утгыг зөв ойлгож энэ талаар монголын хувьсгалтай эв саналаа нэгтгэж байсныг бас тэмдэглэх

3. «МАХН-ын түүхэнд холбогдох зарим чухал баримт бичгүүд» УБ., 1946, 64-65-р тал.

4. «Советско-монгольские отношения» т-1, М. 1975 с 502

5. ЕТА, Ф-1, Т-23, Хн—138, «Власть труда» сонин, 1924 оны 1 сарын 11-ний дугаарт.

6. «Ардын эрх» сонин. 1924.2.5. № 1.

хэрэгтэй юм. Хятадын их хувьсгалч Сунь Ят-сен тэр үед: «Монгол Ард Улсад Орос их нөлөө үзүүлж байна гэлцэнэ. Тэнд Орос улс нөлөөлж байгаа нь харин ч сайн хэрэг. Монгол орон хятадын милитаристууд, Унгерн зэргээс болж хичнээн их хэлмэгдсэнийг бид мэднэ. Монгол эрх чөлөөтэй орон байг»⁷ гэж хэлж байжээ. Кантоны засгийн газрыг толгойлж байхдаа Сунь Ят-сен 1923 оны нэгдүгээр сарын 30-нд Зөвлөлт Орос Улсын бүрэн эрхт төлөөлөгч А. А. Иофкетэй уулзаж ярилцахдаа» Оросын цэрэг Монголоос гарсны дараа Бээжингийн засгийн газар Орос улсын эсрэг чиглэсэн цагаан гвардынхны өдөөн хатгах дайсагнагч ажил лагаа дахин сэргэх явдлыг зогсоох бодолгүй байгаа одоо үед оросын цэргийг нэн даруй гаргахын чухлыг болон тэр нь хятадын үнэнхүү эрх ашигт нийцэж байгааг би олж харахгүй байна»⁸ гэж мэдэгдэж байсан юм. Хятадын Коммунист намыг үндэслэн байгуулагчдын нэг, тууштай интернационалч Ли Да-чажо 1925 онд МАХН-ын төлөөлөгчтэй уулзахдаа хэлсэн үгийг энд бас иш татаж болох юм. «Бид, одоогийн Монголыг биеэ даасан бүрэн эрхт улс хэмээн бүрэн дүүрэн зөвшөөрөхийг хүсч байна. Учир нь Монгол улс Хятадаас тусгаарлаад эрх чөлөөгөө хамгаалж чадсанаар барахгүй империализмыг эсэргүүцсэн тэмцлээрээ хятад хүмүүс бидэнд болон дэлхийн хувьсгалын үйл хэрэгт их тусламж үзүүлж байна»⁹ гэж: Ли Да-чжар хэлжээ. Энэ бүхэн бол бодит байдлыг зөв үнэлсэн ухаалаг хандлага байжээ.

БНМАУ-ын нутаг дэвсгэрээс улаан цэргийн ангиудыг гаргах асуудлыг монгол зөвлөлтийн засгийн газрууд буурьтай шинжлэн үзсэний үндсэн дээр 1925 оны эхээр хэлэлцэн тохирсон нь нийтэд илэрхий билээ. Зөвлөлт Хятадын харилцааг хоёр орны эрх ашгийн үүднээс харилцан зохицуулж, БНМАУ-д хятадын милитаристууд шууд цэрэглэн халдах аюул занал арилсан явдлыг монгол, зөвлөлтийн засгийн газрууд анхааран үзэж, тийм шийдвэр гаргасан юм. БНМАУ-ын нутаг дэвсгэрээс өөрийн цэргийг гаргах тухай саналыг Зөвлөлт засгийн газар тавьсан бөгөөд БНМАУ-ын Засгийн газар тус улсын гадаад байдал бэхжсэнтэй холбогдуулан уг асуудлыг зөвшөөрч байгаагаа мэдэгдээд монголын ард түмний эрх чөлөө, тусгаар тогтнолын үйл хэрэгт улаан армийн дайчдаас үзүүлсэн интернационалч тусламж, мартагдашгүй ач гавьяаг өндөр үнэлж Зөвлөлт засгийн газар, улаан арми, түүний командлалд Монголын хөдөлмөрчин ард түмний гүн их баяр талархлыг дэвшүүлсэн юм. Одоогоос аваад Холбоот улсын ба манай БНМАУ-ын ард түмний жаргал зовлон нь салшгүй холбоотой бөгөөд бидний хоёр улсын ашиг тус ба жинхэнэ ард түмний эрх захиргааны агуу их бодлого суртал нь хөгжин дэлгэрэхдээ харилцан үнэнч, халуун найрамдалтайгаар явах ёстой гэж Монголын жинхэнэ ард түмэн ба түүний засгийн газраас үзнэ. Ерөөс тохиолдох хүнд бэрх цагуудад харилцан туслалцах ба үүний дотор ямар нэгэн учраас 1921 онд тохиолдсон байдалтай адил байдал манай улсад тохиолдох болбаас манай ард түмэн ба Засгийн газар нь Холбоот улс ба түүний «Улаан цэргийн тусламжинд хатуу батаар итгэж байдна»¹⁰ гэж БНМАУ-ын Засгийн газрын тэрхүү нот бичигт өгүүлсэн юм.

7. П. Старицевна. К. вопросу о советско-монгольских отношениях (Труды Московского института востоковедения) сб. 5., 1947, с. 292. (Б. Лхамсүрэн «МАХН-ын үйл ажиллагаанд интернацио-нализмын зарчим хэрэгжсэн нь» гэдэг номын 43-р талд иш татсаныг үз).

8. «Советско-китайские отношения. 1917—1959 гг» М., 1959, стр. 64—65.

9 НТА. Ф1, Т-2, Х-176, хуудас 32.

10 «БНМАУ хөрөнгөтний биш хөгжлийн төлөө тэмцэлд» баримт бичгүүд. УБ., 1956, 329—330-р тал

Чан Кай-шийн харгис бүлгийнхэн хятадын милитаристуудын бодлогыг өвлөн авч, БНМАУ-ыг булаан эзэлж, хавсарган нэгтгэх бодлогоо бас л үргэлжлүүлсээр байжээ. Гоминданы эрх баригчид 1926, 1955 онуудад «Хятадын шинэ атлас», «Хятадын хил» гэдэг газрын зураг боловсруулахдаа өөрийн нутгаас хоёр дахин илүү нутаг дэвсгэрийг оролцуулан зурсны дотор БНМАУ-ын нутаг дэвсгэрийг бүхэлд нь түүнд хамааруулжээ. Чингэхдээ, тэд түүхийн эсрэг шинж бүхий элдэв өнгөлзлөг дурдаж гаргасан юм. Тэрхүү «зурагт» БНМАУ-аас гадна ЗХУ-ын Амар мөрний хавь нутаг, Приморье, Сахалин, Казахстан, Дундад Азийн хэсэг, Афганистаны зарим хэсэг, Солонгос, Непал, Бутан, Бирма, Тайланд, Малайз, Кампучи, Лаос, Вьетнам Дорнод ба Өмнөт хятадын тэнгисийн зарим арал зэргийг хятадын нутагт оролцуулан зурсан ажээ.¹¹ БНМАУ-ын эрх баригчид гоминданы харгисуудын энэхүү өнгөлзөгч бодлогыг бас өвлөн залгамжилж, уг зураг атласыг бүр 1950-иад оны дундуур дахин хэвлүүлснийг үүнтэй холбогдуулан дурдахад илүүдэхгүй юм.

Гоминданы эрх баригчид 1929 оны эхээр БНМАУ-ын бүрэн эрхт байдлыг илтэд басамжилсан агуулга бүхий бичиг удаа дараа ирүүлсэнтэй холбогдуулан ардын засгийн газраас гаргасан нэгэн тогтоолд: «Бидний монгол ард түмэн бол нийтийн их байдлыг хянаж, цаг үест нийлүүлэн, нэгэнт ийнхүү бусдын дарлагдлаас ангижирч, өөрийн эрх чөлөөтэй байдлыг байгуулан тогтоож байгаа зэрэг явдлыг Дундад улсын засгийн газар ба тэдний олон ард иргэн, албаны газрууд цөм тодорхой мэдсээр атлаа энэ мэт өөрийн харьяат нэгэн муж мэтээр үзэж, бичиг зарлалыг ирүүлж байгаа нь их л гайхалтай хэрэг болно. Үүнд: Дундад, Монгол хоёр улс бол зах хязгаар нийлэлдэн суух тул Дундад улсын Засгийн газраас манай Монгол улсыг зөвшөөрөн хүлээж, харилцан найрамдал байгуулсугай гэх бол манай засгийн газраас нэгэн адил зөвшөөрөн хүлээж харилцан найрамдал байгуулж болох ба түүнээс өөр бидний ард олныг өөрсдийн хүчнээр тэмцэлдэн байгуулсан бүрэн эрхтэй засаг төр ба ард олны эрх чөлөөг хэмжээлэх гэх буюу урьд адил Дундад улсын нэгэн муж буюу нэгэн хэсэг газар болгоно гэх зэргийн хэлэлцээн гаргах бол бидний улс хэзээ ч хүлээж огт чадахгүй»¹² гэж тэмдэглэжээ.

Японы түрэмгийлэгчдийг эсэргүүцсэн дайны үед монголын ард түмэн интернационалч үүрэгтээ үнэнч байж, хятадын эх оронч хувьсгалт хүчнүүдтэй эв санааны нэгдлээ цуцалтгүй бэхжүүлсээр байсан юм. Харин гоминданы эрх баригчид энэ үед ч гэсэн БНМАУ-ын бүрэн эрхт байдалд өнгөлзөх бодлогоо үргэлжлүүлж, монгол зөвлөлтийн ард түмний найрамдалт харилцааг эвдэхэд чиглэсэн хорон санаат явууллагаа улам даамж руулсаар байжээ. Хоёр орны хувьсгалт хүчнүүдийн ангийн холбоог бэхжүүлэх шаардлага хэзээ хэзээнээс хурц тавигдсан ийм нөхцөлд Хятадын Коммунист намын доторхи их гүрний дээрэнгүй үзэл баримтлагч Мао Цзэдун тэргүүтэй этгээдүүд үнэн чанартаа Чан Кай-шийн харгис бүлгийнхэнтэй нэгэн эгнээнд зогсож, БНМАУ-ыг хятадад хавсарган нэгтгэх бодлогоо ил далд янз бүрийн хэлбэрээр явуулж байв. 1936 онд Мао Цзэдун Америкийн сэтгүүлч Эдгар Сноутай ярилцахдаа «Монгол бол Хятадаас хууль бусаар таслагдсан нутгийн нэг» гэсэн Чан Кай-шигийнхний үзлийг яг давтаж, түүнийг буцаан нэгтгэх шунахай саналаа илэн далангүй илэрхийлж байжээ. ХКН-ын доторхи Ли Ли-сань нарын зэрэг «зүүн» оппортунист бүлэглэлийн этгээдүүдэд ч гэсэн бас тийм санаа баримталж, БНМАУ-ыг Хятадад хавсарган нэгтгэх зорилтыг биелүүлэхэд японыг эсэргүүцсэн дайныг ашиглах адал балмад төлөвлөгөөг дэвшүүлж байсан юм.

Япон, Хятадын милитаристуудын зүгээс БНМАУ-д довтлон халдах аюул бодитой болсон нөхцөлд, 1936 оны гуравдугаар сард Улаанбаатар хотноо байгуулсан Протокол гэрээний дагуу Зөвлөлтийн цэргийн ангиудыг урьж ирүүлсэн явдал хятадын эрх баригчдын зүгээс монголын эсрэг үзлээ дахин дэвэргэх бас нэгэн шалтаг болсон байна. Хятадын Гадаад яамны сайд Чжан Цюнь ЗСБНХУ, БНМАУ-ын хооронд харилцан туслалцах тухай Протокол гэрээ байгуулсантай холбогдуулан Зөвлөлт Засгийн газарт өгсөн 1936 оны дөрөвдүгээр сарын 7-ны өдрийн нотдоо БНМАУ-ын төрийн тусгаар тогтносон байдлыг үгүйсгэхийг оролдсон элдэв шалтаг зааж тэрхүү гэрээг нэн даруй цуцлахыг шаарджээ.¹³ Зөвлөлт Засгийн газраас 1936 оны дөрөвдүгээр сарын 8-нд ЗСБНХУ-д Хятадын хэргийг түр хамаарагчид өгсөн хариу нотдоо хятадын эрх баригчдын тэрхүү шаардлагыг эрс няцаан, зөвлөлт-монголын хэлэлцээр бол ямар нэг гуравдагч орны эсрэг чиглээгүй бөгөөд биеэ даасан бүрэн эрхт хоёр орны хооронд хэн хэнийхээ аюулгүй байдлын эрх ашгийг харгалзан байгуулсан хэлэлцээр мөн учир тэрхүү протокол гэрээгээр хүлээсэн үүргээ Зөвлөлт засгийн газар тууштай биелүүлнэ гэдгийг тов тодорхой мэдэгдсэн юм. ЗХУ-ын энэ зарчимч байр суурь нь Япон, Хятадын милитарист бүлэглэлийн аль алиных нь зүгээс Монголын талаар явуулж байсан өнгөлзлөгийг таслан зогсоох туйлын чухал хүчин зүйл болсон билээ.

1945 онд Японы империалистуудыг бутниргэхэд зөвлөлт-монголын зэвсэгт хүчин нэгэн эгнээнд хамтран тэмцэж японы милитаризмын үндсэн хүч болж байсан Квантуны армийг шийдвэртэй довтолгоогоор бутцохисон нь дэлхий дахинд энх тайван байдал тогтоох, империализмыг эсэргүүцсэн Азийн ард түмний тэмцлийг хөнгөвчлөх, нэн ялангуяа хятад дахь ардын хувьсгалын ялалтыг түргэтгэхэд асар их ач холбогдолтой үйл явдал болов.

Хятадын милитаристуудын байнгын заналхийллийн дор оршиж байсан БНМАУ-ын ард түмэн 1949 оны аравдугаар сард ялсан Хятадын хувьсгалыг чин сэтгэлээсээ дэмжиж, туйлын их баяр талархалтай угтаж авсан билээ. Хятадын хувьсгалын ялалтын дүнд Монгол-Хятадын ард түмний хоорондох ангийн холбоо пролетарийн интернационализмын зарчим дээр бэхжиж, хоёр орны хооронд харилцан итгэлцэх, нөхөрсгөөр туслалцах, ах дүү ёсоор хамтран ажиллах өргөн бололцоо нээгдсэн юм. ХКН-ын дотор интернационалч үзэл санааны чиглэл зонхилох хандлагатай байсан 50-иад оны эхэн үед тус хоёр орны хооронд ах дүүгийн найрамдалт харилцааны эх суурь тавигдсан билээ.

Тус хоёр орны харилцаа хэвийн байдалтай байсан тэр үед БНМАУ нутаг дэвсгэр дээрээ Зөвлөлтийн цэргийн ангиудыг байлгах байтугай өөрийн зэвсэгт хүчнээ эрс хорогдуулж, хязгаарын цэргээ татан буулгаж байсан нь БНХАУ-тай найрамдал, хамтын ажиллагаагаа бэхжүүлэх гэсэн сайн санааны илрэл байв. Монгол, Хятадын залгаа хил нь нийтдээ 4700 км урт үргэлжилдэг бөгөөд энэ хил амгалан тайван байх явдлаас БНМАУ ын аюулгүй байдал ихээхэн шалтгаалж байв. Хятад улс социализмын замд орсон учраас тус хоёр орны залгаа хил нь Зөвлөлт Холбоот Улстай залгаа хилийн нэгэн адил энх тайван, найрамдал, социализмын хил болно гэж БНМАУ-ын Засгийн газар, Монголын ард түмэн гүнээ итгэж байлаа. Гэтэл Мао Цзэдун, түүний шадар хүмүүс их гүрний дээрэнгүй жанжлах үзлийнхээ уршгаар социализмын орнуудын эсрэг бодлого явуулж,

12 БНМАУ-ын Засгийн газрын «Албан сэтгүүл» 1929, № 45, 53-р тал.

13 «Советско-монгольские отношения» (Документы и материалы), М. 1975 т. 1, с. 341—342.

ленинизм, аугаа их Октябрь, түүний эх орон, Монголын болон дэлхийн хөдөлмөрчдийн үнэнч түшиг ЗХУ-ыг дайсагнан империализмын хамгийн харгис хүчинтэй шууд сүлбэлдэх яамд орсон билээ.

Ийнхүү 60-аад оны үеэс эхлэн Хятадын эрх баригчид БНМАУ-ыг дайсагнан үзэх явдлаа төрийн бодлогын хэмжээнд хүртэл гүнзгийрүүлж үзэл суртлын талаар хорлон сүйтгэх явууллага хийхийн хамт эдийн засаг улс төрийн даралт шахалт үзүүлэх, цэргийн хүчээр айлган сүрдүүлэх зэрэг зүйл бүрийн хэлбэрээр хоёр орны харилцааг нэн хангалтгүй байдалд хүргэсэн юм. Монгол-Хятадын харилцааг ийнхүү хурцатгасан гол шалтгааны нэг бол Бээжингийн эрх баригчид Монголыг БНМАУ-ын Засгийн газрын нот бичигт дурдснаар булаан эзлэх эрмэлзлэлээ орхиогүйгээр үл барам, БНМАУ болон түүний холбоотон ЗСБНХУ-ын эсрэг цэрэг дайны бэлтгэлээ улам хүчтэй болгосоор байгаа явдал мөн.

Бээжингийн эрх баригчдаас Монголын эсрэг явуулж байгаа дайсагнагч үйл ажиллагааны хурц үзүүр нь юуны өмнө Зөвлөлт Холбоот Улсын эсрэг чиглэж байгааг тэмдэглэх хэрэгтэй юм. Монголыг Хятадад хавсарган нэгтгэх дээрэнгүй эрмэлзлэлээ биелүүлэх замд нь монгол-зөвлөлтийн ард түмний найрамдал, цэрэг-улс төрийн хамтын ажиллагаа гол саад болж байгаа учраас тэд энэхүү найрамдлыг эвдэн бусниулахын тулд янз бүрийн арга заль гаргаж, юу ч хийхээс буцахгүй байгаа юм. 1964 оны долдугаар сарын 10-нд Мао Цзэдун японы социалист намын төлөөлөгчидтэй уулзаж ярилцахдаа БНМАУ нь хятадтай нэгдэх ёстой гэсэн хэзээний өнгөлзөгч үзлээ дахин давтахдаа Зөвлөлт Холбоот Улс Монгол орныг «боолчилж колонио» болгосон мэтээр гүтгэн зэмлэж байжээ.

Үүнээс үзэхэд Мао Цзэдун Монгол орныг булаан эзэлж колоничлох гэсэн өөрийн аль хэдийний санаархлаа БНМАУ тусгаар тогтнон оршихын гол тулгуур, авран хамгаалагч болж буй Зөвлөлт Холбоот Улсад гүжирдэж тохсон нь илт байна. Яг ийм агуулга бүхий гүтгэлгийг 30-аад оны үед гоминданы үзэл сурталчид нэг биш удаа гаргаж байлаа.¹⁴ Японы социалист намын төлөөлөгчидтэй Мао Цзэ-дун ийнхүү ярилцсаны дараагаар БНМАУ-ын эсрэг Бээжингийн эрх баригчид цэрэг дайны бэлтгэлээ улам идэвхжүүлсэн нь санамсаргүй хэрэг биш юм. БНМАУ-тай хил залгаа нутагт цэргийн томоохон хүч байрлуулж, цэрэг-стратегийн чанартай элдэв барилга төхөөрөмж босгон, цэргийн сургуулийг олонтоо хийж байгаа нь одоо хэнд ч нууц зүйл биш болоод байна. Гадаадын хэвлэлийн мэдээгээр бол Хятад улс цэргийн гол хүчнийхээ тэн хагасыг ЗХУ, БНМАУ-ын хил дээр төвлөрүүлээд байгаа юм. Чухам үүнтэй холбогдуулан БНМАУ-ын Засгийн газар өөрийн нотдоо: «Хятадын эрх баригчид Монгол улсыг булаан эзлэх эрмэлзлэлээ орхиогүйгээр үл барам, БНМАУ болон түүний холбоотон ЗСБНХУ-ын эсрэг цэрэг дайныхаа бэлтгэлийг улам хүчтэй болгосоор байгаа учраас манай улсын бүрэн эрхт байдал, тусгаар тогтнолд заналхийлэх аюул хэвээр байна гэж БНМАУ-ын Засгийн газар үзэж байна» гэж цохон тэмдэглэсэн юм.

ЗХУ ба БНМАУ-ын эсрэг хятадын эрх баригчид цэрэг дайны бэлтгэлээ идэвхжүүлсэн явдал чухам юунаас шалтгаалж байна вэ гэсэн асуулт зүй ёсоор гарч байгаа юм. Хятадын суртал нэвтрүүлгийн нотолгоогоор бол «Зөвлөлтийн аюул» гэгч л тийнхүү цэрэг дайны хэнээрхэл дэгдээхийн үндэс болж байгаа ажээ. Гэтэл бодит баримтууд Бээжингийн суртал нэвтрүүлгийн энэхүү явцгүй нотолгоог туйлын тодорхой няцааж байгаа билээ. ЗСБНХУ-ын Дээд Зөвлөлийн Тэргүүлэгчдээс Бүх Хятадын

14 Тан Ян-у. Прошлое и современное положение Внешней Монголии Шанхай. 1935, с. 25. «Намын амьдрал» сэтгүүлийн 1968 оны 5-рт иш татсаныг үз.

Ардын Төлөөлөгчдийн Хурлын Байнгын хороонд илгээсэн 1978 оны 2-р сарын 24-ний уриалга нь зөвлөлт-Хятадын харилцааг хэвийн болгож, улс түмний хоорондын энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэх эрх ашгийн үүднээс үр бүтээлтэй хамтран ажиллах тодорхой саналыг дэвшүүлсэн чухал баримт бичиг мөн юм. Гэтэл хятадын эрх баригчид уг уриалгад нааштай хариу өгөх нь байтугай, хоёр улсын харилцааг хурцатгахад чиглэгдсэн үйл ажиллагаагаа улам идэвхжүүлсэн нь тэдний үнэнхүү нүүр царайг дахин илчлэн харуулав.

Үүнээс үндэслэн «Зөвлөлтийн аюул» гэгчийн тухай хятадын эрх баригчдын дэгдээж байгаа суртал нэвтрүүлгийн шуугианы мөн чанарыг дэлхийн олон нийт улам сайн ойлгон авч байна. Тэдний энэ явууллага бол Хятад орон эргэн тойрон дайсны хүрээлэлд оршиж байгаа мэтээр хятадын хөдөлмөрчдөд үнэмшүүлэх, тэр үндсэн дээр хүн амын дотор зөвлөлтийн эсрэг үзлийг цаашид дэлгэрүүлж, үндсэрхэг, их гүрний даварсан дээрэнгүй үзлийг улам дэвэргэн, жанжлан ноёрхох санаархлаа хэрэгжүүлэх үзэл суртлын үндсийг бэхжүүлэхэд л чиглэж байна. Хятадын эрх баригчид Зөвлөлт Холбоот Улс хэзээ ч эхлэж довтолхогүй гэдгийг сайн мэдэж байгаа бөгөөд тэдний тооцоо өөр зүйлд чиглэж байгаа юм.

Зөвлөлтийн цэргийн ангиудыг Монголоос гаргах шаардлага тавихдаа Хятадын эрх баригчид БНМАУ-ыг эзлэн түрэмгийлэх замаа цэвэрлэх гэсэн жинхэнэ санаагаа нууж, харин манай орны бүрэн эрхт байдал, тусгаар тогтнолын төлөө «сэтгэл зовж» байгаа мэт дүр үзүүлэхийг оролдож байгаа нь монголын ард түмний гүн их эгдүүцлийг төрүүлж байна. Энэ бол БНМАУ-ын тусгаар тогтносон байдлыг басамжилсан хэрэг төдийгүй, монголын ард түмний үндэсний ухамсрыг шууд доромжилсон хэрэг мөн. БНМАУ 57 жилийн турш бүх талын холбоо найрамдал, түүний дотор манай хоёр ард түмний цэрэг-улс төрийн холбоо бол тус орон эрх чөлөөтэй, биеэ даан оршихын зайлшгүй баталгаа мөн гэдгийг сайтар ойлгож авсан юм. Нөхөр Ю. Цэдэнбалын хэлснээр: «Нийтийн дайсныг эсэргүүцсэн хамтын тэмцлийн гал дөлд хатаагдсан Монгол-Зөвлөлтийн ард түмний дайчин холбоо, Монгол-Зөвлөлтийн зэвсэг нэгт хамтын нөхөрлөл бол хэзээнээс нааш манай нам, монголын бүх ард түмний бахархал болж ирсэн билээ».

Хятадын милитаристууд ба Чан Кай-шийн харгисуудын үеэс уламжлан ирсэн их гүрний дээрэнгүй үзэл, өнгөлзлөг нь БНМАУ-ын талаар өнөөгийн хятадын эрх баригчдын баримталдаг бодлого, явууллагын уг сурвалж болсоор байна. Учир иймээс улс орныхоо тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хангахын тулд ЗХУ-ын цэргийн ангиудыг Монголд түр байлгаж байгаа нь тус орны аюулгүй байдлын эрх ашгийн үүднээс үүсч гарсан зайлшгүй чухал арга хэмжээ мөн. 1966 оны нэгдүгээр сарын 15-нд тус хоёр орны хооронд байгуулсан найрамдал, нөхөрлөл, харилцан туслалцах тухай гэрээнд: «Хэлэлцэн тохирогч эрхэм хоёр этгээд социалист хамтын нөхөрлөлийн батлан хамгаалах хүчийг хэлбэрэлтгүй зузаатгах зорилтод нийцүүлэн тус хоёр орны батлан хамгаалах хүч чадлыг хангахад харилцан тусламж үзүүлнэ. ...Тус хоёр орны эрх тэгш буюу энх тайван, олон улсын хамтын ажиллагааны эрх ашгийг хөндсөн олон улсын нэн чухал бүх асуудлаар зөвлөн хэлэлцэж байх бөгөөд сайхан уламжлынхаа үзэл санаа, түүнчлэн Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн үзэл санааг баримтлан үйл ажлаа явуулж, тус хоёр орны аюулгүй байдал, тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хангах зорилгоор шаардагдах бүх арга хэмжээ, түүний дотор цэргийн талын арга хэмжээг хамтран авч байна» гэж заасан билээ. Олон улсын эрх зүй, хоёр орны уламжлалт найрамдал, хамтын аюулгүй байдлын эрх ашгийн дагуу зөвлөлтийн

цэргийн ангиудыг түр байлгаж байгаа нь манай орны цэвэр дотоод хэрэг мөн бөгөөд БНМАУ-ын Засгийн газрын нотод дурдсанчилан Зөвлөлтийн цэргийн ангиудыг гаргах явдал нь гагцхүү түүнийг ирүүлэх болсон шалтгаан арилсан цагт л яригдаж болох нь хэн бүхэнд илэрхий юм.

Д. Даш

ПЕКИНСКИЕ РУКОВОДИТЕЛИ УНАСЛЕДОВЫВАЮТ ПОЛИТИКУ КИТАЙСКИХ МИЛИТАРИСТОВ

Резюме

На Всекитайском Совещании Народных представителей, состоявшемся весной 1918 года, китайские лидеры потребовали от Советского Союза вывода советских военных подразделений с территории МНР, что является новым актом бесперемонного вмешательства во внутренние дела суверенного монгольского государства. В связи с этим требованием правительство МНР отправило правительству КНР ноту, в которой был дан решительный отпор великодержавным притязаниям китайских лидеров в отношении МНР.

Это требование китайского руководства, игнорирующее существование суверенного монгольского государства, лишней раз напоминают политику китайских милитаристов и чанкайшистов в отношении молодой, революционной Монголии в 20-30-х гг. Нынешняя политика Пекина, направленная против МНР и ее верного союзника СССР, в основе имеет непосредственную преемственность с традиционной политикой китайских милитаристов.

Китайское руководство, так же как и китайские милитаристы в прошлом, предъявляют МНР необоснованные территориальные притязания, грубо вмешиваясь во внутренние дела нашего государства.

Автор пишет о том, как милитаристские круги гоминьдановского Китая распространяли различного рода небылицы относительно пребывания в МНР воинских частей Красной Армии, находившихся по просьбе Народного правительства в 20-30-х гг. для защиты независимости страны от внешних агрессоров.

В статье особо отмечается, что именно Договор о дружбе и мире с Советским государством послужил основным препятствием осуществлению агрессивных замыслов китайских лидеров присоединить МНР к Китаю. Еще в свое время гоминьдановские реакционеры всячески пытались подорвать нерушимую монголо-советскую дружбу с целью открыть путь к завоеванию МНР.

В начале 50-х годов, когда внутри КПК преобладала тенденция интернационалистских взглядов, было заложено начало равноправного сотрудничества между МНР и КНР. Монгольский народ надеялся, что КНР имеющая общую границу с МНР на протяжении 4700 км, встав на социалистический путь развития, будет развивать отношения братской

дружбы и сотрудничества на благо народов обеих стран. Однако, уже начиная с 60-х годов китайские лидеры приступили к проведению открыто враждебной политики в отношении МНР. Непосредственную угрозу безопасности МНР представляют открытые военные приготовления в районах Китая, граничащих с МНР.

В заключение автор отмечает, что пребывание советских воинских частей в МНР, находящихся по просьбе монгольского правительства, является крайней необходимостью для защиты суверенитета и безопасности страны до тех пор, пока не будет устранена угроза со стороны Пекина.